

**Стандарт**

**E12 – Агаарын чанарыг хамгаалах тухай стандарт**

2014 оны зургадугаар сар

Төрөл  Стандарт	Гарчиг: <b>Агаарын чанарыг хамгаалах</b>			Баримт бичгийн дугаар: <b>HSEC-B-03</b>
	Үйл ажиллагаа: <b>Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчин, Орон нутаг (ЭМААБООН)</b>			
	Хуудасны тоо: <b>3</b>			
	Гүйцэтгэх хороо баталсан огноо:  <b>2014 оны зургадугаар сарын 20</b>	Хүчин төгөлдөр болох огноо:  <b>2015 оны дөрөвдүгээр сарын 1</b>	Дараахийг орлоно:  <b>E2 - Агаарын чанарын хяналт</b>	Доорх огнооноос өмнө хяналт шалгалт хийхгүй:  <b>2015 оны дөрөвдүгээр сарын 1</b>
Хариуцагч: <b>Группийн Эрүүл мэнд, Аюулгүй ажиллагаа, Байгаль орчин, Орон нутгийн асуудал хариуцсан захирал</b>	Баталсан: <b>Гүйцэтгэх хороо</b>		Хэнд зориулах: <b>Рио Тинтогийн бүх ажилтан, Рио Тинто Группийн салбар компани, хэлтэс нэгж бүрт</b>	
Энэхүү стандартай шууд хамааралтай бусад бодлого, стандарт, журам, зааварчилгаа: <b>Рио Тинтогийн удирдлагын тогтолцооны стандарт, E12 – Агаарын чанарыг хамгаалах тухай зааварчилгаа</b>				
Баримт бичгийн зорилго : <b>Группийн байгаль орчны бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Энэхүү стандартад агаарын чанарын менежменттэй холбоотой үйл ажиллагаа ба/буюу нөхцөл байдалд тавигдах наад захын шаардлагыг тодорхойлох бөгөөд эдгээрийг биелүүлэхгүй байх нь Группийн хэмжээнд бодит нөлөөлөл үзүүлнэ.</b>				

# E12 – Агаарын чанарыг хамгаалах

## Хамрах хүрээ ба зорилго

Энэхүү стандарт нь Рио Тинто компанийн удирдлагад хамаарах бизнесийн нэгж, компаниудын хайгуул судалгааны шатнаас уурхайн хаалт хүртэлх бүхий л үйл ажиллагаанд мөрдөгдөнө.

Зуухны яндан зэрэг цэгэн эх үүсвэрээс ялгарах бохирдол, мөн овоолго, хаягдлын хоолой зэргээс гарах сарнимал бүх төрлийн эх үүсвэрээс ялгарах агаарын бохирдлын асуудлыг энэхүү стандартаар зохицуулна.

## Гүйцэтгэлийн шаардлагууд

1.1 Бидний явуулж байгаа бизнесийн үйл ажиллагааны улмаас агаарын бохирдол үүсч, үйл ажиллагааны талбайн гадна хүний эрүүл мэнд, байгаль орчин, биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээнд хор хөнөөл учруулахаас хамгаална.

1.2 Агаарын бохирдлын нөлөөллийн улмаас одоо болон ирээдүйд учруулж болзошгүй сөрөг нөлөөг тоон үзүүлэлтээр хэмжинэ.

1.3 Үйл ажиллагааны хэвийн болон боломжит хамгийн муу нөхцөлд, мөн цаг уурын хэвийн болон боломжит хамгийн муу нөхцлүүдийн аль алинд нь үйлчилж буй шаардлага үзүүлэлтүүд зөрчигдөхөөс сэргийлнэ.

1.4 Засгийн газрын зохицуулалт байхгүй, бүрэн бус, эсвэл хүний эрүүл мэнд, байгаль орчин, биологийн олон янз байдал, экосистемийг хамгаалах асуудлыг зохицуулаагүй бол гүйцэтгэлийн дотоод шалгуур үзүүлэлтийг боловсруулж мөрдөнө. Холбогдох хууль тогтоомжоос илүү чанга гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулж мөрдөх бол тухайн бизнесийн нэгжийн удирдах захирлаас албан ёсны зөвшөөрөл авна.

## Хяналтын шаардлагууд

Энэхүү гүйцэтгэлийн стандартад тусгагдсан менежментийн тодорхой шаардлагууд нь Рио Тинтогийн удирдлагын тогтолцоонд тодорхойлсон аливаа ерөнхий шаардлага дээр нэмэлтээр үйлчилнэ.

### *Төлөвлөлт*

2.1 Энэхүү стандарт дахь удаах зүйл заалтуудыг хангаж ажиллахад шаардагдах хүчин чармайлтын түвшинг энэхүү стандартын дагалдах зааварчилгаанд тайлбарласан хамаарлын босго үзүүлэлтээр тодорхойлно.

2.2 Үйл ажиллагаанаас ялгарах агаар бохирдуулагч томоохон эх үүсвэрүүдийг тогтоон тодорхойлж, бүртгэж баримтжуулна.

2.3 Үйл ажиллагааны талбай орчмын агаарын чанарын суурь үзүүлэлт болон цаг уурын шинж байдлуудыг тодорхойлж, бүртгэн баримтжуулна.

### *Хэрэгжүүлэлт ба ашиглалт*

2.4 Өөрчлөлтийн менежментийг хэрэгжүүлэхээс өмнө агаартай холбоотой эрсдэл болон нөлөөллийг авч үзэж, хэрэгжүүлэх боломжтой нөлөөллийн арилгах болон бууруулах боломжуудыг судлан, өөрчлөлтийн менежментэд бүртгэж оруулна.

2.5 Томоохон төслийн техникийн болон санхүүгийн үнэлгээний хүрээнд агаартай холбоотой эрсдэл, нөлөөллийн судалгааг хийж баримтжуулна.

### *Хяналт шинжилгээ*

2.6 Орчны агаарын чанарын хяналт шинжилгээний хөтөлбөр хэрэгжүүлнэ. Тухайн нөлөөлөл, эрсдэл нь үл ялиг нөлөөлөлтэй байвал хүний эрүүл мэнд, байгаль орчин, биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээнд үзүүлэх нөлөөллийг харуулахдаа агаарын чанарын тархалтын загварчлал ашиглаж болно.

2.7 Утаа ялгаруулах томоохон эх үүсвэрийг тоон үзүүлэлтээр хэмжихийн тулд агаар бохирдуулагч эх үүсвэр дээр хэмжилтийн хөтөлбөр хэрэгжүүлэх эсвэл тооцоолох аргачлал ашиглана.

2.8 Агаар бохирдуулагч бүхий л томоохон эх үүсвэрийн орчны нөлөөллийг тодорхойлж, эх үүсвэрүүдийг орчны нөлөөлөл дэхь эзэлж буй хувиар нь эрэмбэлнэ.